

Сургуулийн сурагчдын сүрьеэ өвчний талаарх мэдлэг, хандлагыг үнэлсэн дүн, 2016 он, Монгол улс

Сүвд Б.¹, Энхболд С.², Ононгоо А.¹, Энхтуяа П.¹, Циенцогзол Д.¹, Уянга Г.¹,
Өнөрсайхан Х.¹, Цэрэндолгор Ц.¹, Цогтбаатар Б.¹

¹Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

²Эрүүл мэндийн яам

Үндэслэл

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээллээ бусдад түгээх үе тэнгийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2009 оноос Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгээр дамжуулан хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд аймаг, дүүргийн өвчлөл өндөртэй сум, хороодоос сонгож авсан нийслэлийн 6 дүүргийн 15 дунд сургуулийн 299, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Сүхбаатар, Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Ховд, Увс, Говь-Сүмбэр, Өмнөговь, Дундговь, Баян-Өлгий аймгийн нийт 20 дунд сургуулийн 396 үе тэнгийн сургагч нар бэлтгэгдсэн.

Зорилго

Төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн сурагчдын сүрьеэ өвчний талаарх мэдлэг, хандлагыг судалж, зөвлөмж боловсруулах

Материал, арга зүй

Үнэлгээг баримт бичгийн, тоон болон чанарын (ганцаарчилсан, бүлгийн ярилцлага) арга зүйг баримтлан явуулсан. Түүвэрлэлтэд үе тэнгийн сургагчаар бэлтгэгдэж байгаа 8-12 дугаар ангийн 7 сургууль (хот ба хөдөө)-ийг хамруулав. Судалгааны тоон мэдээллийн статистик боловсруулалтыг SPSS программын 21 хувилбарыг ашиглан хийв.

Үр дүн

Үнэлгээнд 4 аймаг, УБ хотын 7-12-р ангийн нийт 2505 сургуулийн сурагчид хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 49.5 хувь нь УБ хотын, дундаж нас 15±1.4, хамгийн бага нь 12, хамгийн ахмад нь 18 настай, дийлэнх нь эмэгтэй, 8-р ангид суралцдаг, 5-7 ам бүлтэй, өөрийн гэрт амьдардаг байна. Сурагчдын 56.3% нь төсөлд хамрагдсан, 43.7% нь төсөлд хамрагдаагүй сургуулийн сурагчид байна. Сурагчдын 55.3% нь сургуульд сурч байх хугацаандаа сүрьеэ өвчний талаарх мэдээллийг авч байсан гэжээ. Сурагчдын 76.0% нь сүрьеэ өвчин амьсгалын замаар халдварладаг хэмээн мэдэж байна. Тэдний 16.5% нь сүрьеэ өвчин ямар замаар халдварлах талаар мэдэхгүй, 8.6% нь аяга таваг, гар нүүрний алчуураар буюу ахуйн замаар халдварлана гэсэн байв. Судалгаанд хамрагдсан 4 хүүхдийн 1 нь сүрьеэгээр өвдсөн үед ямар шинж тэмдэг илрэх талаар мэдэхгүй байлаа. Сурагчдын 92.3% нь сүрьеэ өвчнөөр бүх хүн өвдөх боломжтой, 74.5% нь сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд бусдад халдаахгүйн тулд ханиалгах үедээ маск зүүх хэрэгтэй гэжээ. Сурагчдын 65.2% нь сүрьеэ эдгэрдэг, 54.8% нь эрүүл мэндийн байгууллагад хандаж сүрьеэ өвчнийг эмчлүүлнэ гэжээ. 10 сурагчийн 1 сүрьеэ өвчин удамшдаг гэсэн ойлголттой байлаа. Сурагчдын 81.5% нь сүрьеэ өвчнөөр

өвчилсэн хүн дахиж өвдөж болно гэсэн зөв мэдлэгтэй байна. Сүрьеэ өвчин амьсгалын замаар дамждаг, сүрьеэ эдгэрдэг өвчин, эмчилгээний үнийг улсаас хариуцдаг, сүрьеэгээр өвдсөн хүн дахин өвдөж болно гэдгийг төсөлд хамрагдсан сурагчид статистик магадлал бүхий илүүтэй мэдэж байлаа. Судалгаанд хамрагдсан сурагчдаас хэрвээ чи өөрөө сүрьеэгээр өвдвөл чамд ямар мэдрэмж төрөх вэ гэсэн асуултад оролцогчдын 35.6% нь айдас, 34.5% нь үнэхээр хүнд, хэцүү мэт санагдана гэжээ. Сурагчдын дийлэнх нь сүрьеэ өвчин тусахад эцэг эх, эмч эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцахыг хүснэ гэсэн зөв хандлагатай байгаа нь тэдний 62.1% нь сүрьеэ өвчин тусахад хамгийн түрүүнд эцэг эхтэйгээ ярилцахыг хүснэ гэсэн хариултаас харагдаж байна. Үнэлгээнд хамрагдсан сурагчдын 30.6% нь сүрьеэ өвчтэй хүнийг хараад өрөвддөг, гэхдээ хол байхыг хичээдэг гэсэн бол 22.7% нь би өрөвдөж туслахыг хичээдэг гэжээ. Сурагчдын 15.6% нь сүрьеэ өвчний талаар мэдлэгтэй гэж өөрсдийгөө үнэлсэн байна. Үнэлгээнд хамрагдсан нийт сурагчдын 89.5% нь сүрьеэ өвчний талаарх мэдлэг хэрэгцээтэй гэжээ.

Дүгнэлт:

Үе тэнгийн сургагч бэлтгэх хөтөлбөр төлөвлөсний дагуу үе тэнгийн сургагчийг амжилттай бэлтгэсэн байгаа нь төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сурагчдын мэдлэг, хандлагаас ажиглагдлаа. Цаашид сүрьеэ өвчний илрэх шинж тэмдэг, удамшдаг эсэх, эдгэрэлт, эмчилгээний талаарх мэдлэгийг түлхүү өгөх хэрэгтэй болох нь харагдлаа.